

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ,
СУМДЫН 2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2023.12.05

Сүхбаатар сум

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Европын Холбооны санхүүжилттэй “Бүгд залуусын төлөө, залуус бүгдийн төлөө” төслийг “Каритас Чех Републик” олон улсын төрийн бус байгууллага, “Иргэний боловсролын төв” ТББ, “Монголын Залуучуудын эвсэл” ТББ хамтран залуучуудын оролцоог бодлого болон шийдвэр гаргалтын түвшинд хэрхэн хангах, оновчтой аргуудыг сонгох бодлогын хэлэлцүүлгийг орон нутгийн шийдвэр гаргагчид болон залуучуудын асуудал эрхэлсэн төрийн албан хаагчдад зориулан 11 дүгээр сарын 01-02-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Сэлэнгэ аймгийн Ерөнхий боловсролын 35 сургуулийн Сургалтын менежерүүд аймгийн Боловсрол шинжлэх ухааны газраас явуулж буй сургалтад хамрагдах үеэрээ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргатай уулзах хүсэлт гаргасны дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Нарантуяа 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр уулзалт товлон, тус уулзалтын үеэр багш ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний талаар болон орон нутагт ажиллах орчин нөхцөл, нийгмийн баталгаа, сургалтын чанарыг сайжруулах, сургуулиудын гадаад харилцааг хөгжүүлэх талаар санал солилцлоо.

2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр хуралдсан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 140 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй Гацуурт ХХК болон түүний хамаарал бүхий бусад иргэн, аж ахуйн нэгжүүдийн газар эзэмшилт, ашиглалтын байдалтай газар дээр нь танилцаж, санал дүгнэлтээ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд танилцуулахаар Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн, Алтанбулаг, Шаамар, Ерөө зэрэг 10 суманд ажиллаж, сумын удирдлагууд, ард иргэд, малчдын төлөөллүүдтэй газар дээр нь уулзаж тэдний санал бодлыг нэг бүрчлэн сонсож, ажиллалаа.

Ажлын хэсэг тухайн газруудад ажиллахдаа:

- Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалтын дагуу газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг хэрхэн шийдвэрлэж ажилласан талаар сумын Засаг даргын шийдвэр, холбогдох баримт бичигтэй танилцах
- Газрын ашиглалт, эзэмшилтийн байдалтай газар дээр нь танилцах / Гацуурт ХХК болон түүний хамаарал бүхий бусад аж ахуйн нэгжүүдийн/
- Иргэдийн төлөөлөлтэй уулзаж, санал хүсэлтийг сонсох
- Аймгийн ИТХ-ын 2013 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Малчид, тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам”-ын хэрэгжилттэй танилцах
- Усны тухай хууль болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийг шалгах

- Орон нутагт ажилласан шалгалтын дүнг аймгийн ИТХ-ын XVIII хуралдаанд танилцуулах буюу аймгийн нутаг дэвсгэрт хэрхэн үйл ажиллагаа эрхэлж байгааг үнэн бодитой үнэлэх, хурлын төлөөлөгчдийг нэгдсэн мэдээллээр хангах үүрэгтэй ажилласан.

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хурал 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр дараах асуудлуудыг хэлэлцлээ. Үүнд:

1. "Жендерийн эрх тэгш байдлыг хангах" аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл
2. Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийн талаарх мэдээлэл
3. Зарим сумдын /Зүүнбүрэн, Түшиг/ ИТХ-ын үйл ажиллагааны тайлангийн талаар

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Улаанбаатар хотод 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Сэлэнгэ аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүд, яам, агентлагийн төлөөлөл, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, сумдын Засаг дарга, Нутгийн зөвлөлийн дарга, Сэлэнгэ аймагт болон нийслэл, бусад аймагт бизнес эрхэлдэг аж ахуйн нэгжийн төлөөллийн 250 хүнийг хамруулсан "СЭЛЭНГИЙН ИРЭЭДҮЙ-ТОГТВОРТОЙ НОГООН ХӨГЖИЛ" сэдэвт төр, хувийн хэвшлийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Алсын хараа – 2050", "Хөдөөгийн сэргэлт" хөтөлбөрийн хүрээнд Сэлэнгэ аймаг "Нээлттэй Сэлэнгэ" цуврал арга хэмжээг нийслэл Улаанбаатар хотноо 11 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд "Сэлэнгийн ирээдүй тогтвортой ногоон хөгжил" нэгдсэн хуралдаанаар эхэлж, Монгол бөхийн өргөөнд аймгийн брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, урлаг соёлын арга хэмжээ, улс, аймгийн алдар цолтой бөхчүүдийн барилдаанаар өндөрлөлөө.

Монгол-Оросын найрамдлын сарын хүрээнд ОХУ-ын Элчин сайдын яамтай хамтран Орос хэл-соёлын бүсийн арга хэмжээг 2023 оны 11 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд Сүхбаатар суманд зохион байгуулахад манай аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын төлөөлөл болон Хөвсгөл, Төв, Булган, Дархан-Уул, Орхон аймгийн багш суралцагчид оролцлоо.

"Гадаад харилцааг эдийн засагжуулах нь" хөтөлбөрийн хүрээнд ОХУ-ын "Газопровод Союз Восток" компани Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд "Лингафоны анги" нээлээ.

Төрийн албаны ерөнхий шалгалтыг 11 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулж, шалгалт өгөхөөр бүртгүүлсэн нийт 116 иргэнээс 84 иргэн нь шалгалтдаа хамрагдаж, 37 иргэн буюу 44,0 хувь нь тэнцлээ.

E-Mongolia систем дэх орон нутгийн байгууллагуудын үйлчилгээг дахин загварчилж, шинээр нэвтрүүлэх үйлчилгээг судлах ажлын хүрээнд "И-Монгол академи" УТУГ-ын баг бүрэлдэхүүн 11 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 24-ний хооронд Сэлэнгэ аймгийн 25 байгууллагатай уулзалт хийж цахимаар үзүүлдэг 73 үйлчилгээний процессын судалгаа авч, 7 шийдвэрлэх албан хаагчийн эрхийн тохиргоо болон мэдээллийг шинэчиллээ.

Өсвөр үе, залуучуудыг түүх, соёлоо дээдэлсэн, эх оронч үзэлтэй, үүрэг хариуцлагаа ухамсарласан иргэн болж төлөвшүүлэх зорилгоор 16 нас хүрч иргэний

үнэмлэх авч байгаа 50 залуусын төлөөллийг оролцуулан МУ-ын Ерөнхий сайдын ивээл дор 21 дэх удаагаа Иргэний андгай өргөх ёслолын арга хэмжээг зохион байгууллаа.

Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтад тэнцэн салбар бүрт ажиллаж байгаа алба хаагчдын төлөөлөл эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулан үнэнч шударгаар ажиллахаа тангараглалаа. Энэ жилийн тухайд манай аймагт 58 алба хаагч тангараг өргөлөө.

Сэлэнгэ аймгийн ургацын баярын хүрээнд Ойн гавьяат ажилтан, МУ-ын Хөдөлмөрийн баатар Б.Жамсрангийн нэрэмжит үндэсний бөхийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах 60 дахь удаагийн барилдаан Сэлэнгэ аймгийн төвд амжилттай зохион байгуулагдаж, нийтдээ 20 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 85 оролцогч оролцлоо.

Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:

Гамшиг ослын дуудлагын талаар

Тайлангийн хугацаанд объектын гал түймрийн 16, эрэн хайх, аврах ажиллагаа 2 нийт 18 удаагийн гамшиг осол, гал түймрийн дуудлагаар гарч иргэн, аж, ахуйн нэгж байгууллагын 214 сая төгрөгийн өмч хөрөнгийг гал түймэр, гамшиг ослын аюулаас авран хамгаалж ажилласан.

Урьдчилан сэргийлэх чиглэлээр

Тогтвортой хөгжилд эрсдэл учруулж байгаа хүчин зүйлүүдийг бууруулах урьдчилан сэргийлэх бодлогыг оновчтой тодорхойлох, үр дүнтэй хэрэгжүүлэхэд талуудын оролцоог хангах зорилгоор төр болон хувийн хэвшлийн салбар, Монгол Улсад суугаа Олон Улсын байгууллагын төлөөлөгчдийг оролцуулсан “Эрсдэл ба стандарт” үндэсний форумыг Монгол Улсын Шадар сайдын ивээл дор 2023 оны 11 дүгээр сарын 20-оос 22-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Тус форумын хүрээнд Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаа болон Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуулийг сурталчлах өдөрлөгийн арга хэмжээг Баянгол, Мандал, Сайхан, Сүхбаатар, Хүдэр суманд зохион байгуулж нийт 2014 иргэнийг хамруулж, гамшгаас урьдчилан сэргийлэх 6 төрлийн сэрэмжлүүлэг материалаас 841 ширхгийг тараан ажилласан.

“Гал түймэр гарах шалтгаан нөхцөл” цуврал 1 төрлийн сэрэмжлүүлэг шторк бэлтгэж байгууллагын цахим хуудсанд байршуулахад хандалтын тоо 2,000 хүрсэн байна.

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагааны талаар:

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 1-р дунд сургуулийн 9-р ангийн сурагчдад “Стандарт, хэмжилзүй, тохирлын үнэлгээ, баталгаажуулалт”-ын талаар мэдээлэл өгч, итгэмжлэгдсэн хими, хор судлал, нян судлал, ургамлын үр, хорио цээрийн лаборатори болон цахилгаан, даралт, масс, эзлэхүүний лабораторийн үйл ажиллагаатай танилцууллаа. Мөн тохирлын баталгаажуулалтын талаар сонирхсон сурагчдыг мини маркет, түргэн хоолны газарт хийх тохирлын үнэлгээний ажилд оролцуулж, байгууллагын үйл ажиллагааг сурталчлав.

Аймгийн хэмжээнд хэмжих хэрэгслийн тооллого хийх ажлын хүрээнд бүх сум, байгууллагад холбогдох албан тоотыг хүргүүлэн судалгааг гаргуулан авч нэгтгэн Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлээ.

Итгэмжлэгдсэн лаборатори нь нийт 68 аж ахуй нэгжийн 281 дээжид 568 үзүүлэлтээр шинжилгээ хийхэд 5 аж ахуй нэгжийн 12 дээж 31 үзүүлэлтээр шаардлага хангахгүй гарч, нийт дээжийн 4.27 хувийг эерэг сорьц эзэлж байна.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

11 сард 956 баримтаар 20,6 тэрбум төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Орон нутгийн төсвийн нийт орлого		96,766,952.5	67,506,040.7	580.5
1.1	Орон нутгийн төсвийн орлого	47,225,709.8	27,067,155.0	57.3
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	21,083,455.6	15,326,225.0	72.7
	Сумдын төсвийн орлого	26,142,254.2	11,740,930.0	44.9
1.2	Сумдаас авах орлогын шилжүүлэг	4,819,543.2	4,452,812.5	92.4
1.3	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	6,240,661.2	6,240,661.2	100.0
1.4	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	8,255,036.8	8,255,036.8	100.0
1.5	Хандив /Орон нутгийн хөгжлийн сан/	2,735,242.2	2,735,242.2	
1.6	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,404,173.4	1,489,902.5	106.1
1.7	Сум хөгжүүлэх сангийн орлого	2,611,369.1	1,503,813.1	57.6
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		96,766,952.5	68,718,146.0	71.0
2.1	Орон нутгийн төсвийн нийт зарлага	96,766,952.5	68,718,146.0	71.0
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	42,182,802.6	32,549,229.3	77.2
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	14,831,807.5	9,565,984.8	64.5
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	39,752,342.4	26,602,931.9	66.9
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	7,543,017.3	3,307,996.8	43.9
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	8,643,409.3	6,195,432.6	71.7
	Халамжийн сан	130,200.0	96,739.0	74.3
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	17,082,034.0	14,266,760.2	83.5
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	1,055,273.8	936,688.3	88.8
	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	5,298,408.0	1,799,315.0	34.0
3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		15,429,954.5	12,293,360.6	89.9
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	6,786,545.2	6,097,928.0	89.9
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	-	-	-

	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	-	-	-
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	-	-	-
	Хөрөнгө оруулалтын зардалд	-	-	-
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	8,643,409.3	6,195,432.6	-
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	8,643,409.3	6,195,432.6	-
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд			
	Усан хангамжийн татаас	-	-	-
4. Тусгай сангуудын зарлага		2,611,369.1	1,503,813.1	57.6
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	2,611,369.1	1,503,813.1	57.6

2.Өргөн хэрэглээний барааны үнэ:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2022 – Х	2023 – Х	<u>2023 - Х</u> <u>2022 - Х</u>
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	Талх, гурил, будаа			
	Гурил /Алтантараи, I зэрэг, кг/	1 600	3 067	191.7
	Талх /орон нутгийн, ш/	1 500	2 300	153.3
	Нарийн боов /кг/	5 000	5 934	118.7
	Будаа /кг/	3 500	3 967	113.3
	Элсэн чихэр /кг/	3 300	4 534	137.4
2	МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	9 000	10 500	116.7
	Үхрийн мах /кг/	11 000	11 750	106.8
	Адууны мах /кг/	8 000	11 000	137.5
	Ямааны мах /кг/	8 000	9 000	112.5
	Дотор мах, цувдай /цусгүй/	5 000	8 000	160.0
	Хиам /чанасан, кг/	16 500	16 667	101.0
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1 200	2 334	194.5
	Сүү / савласан, л/	4 500	4 550	101.1
	Тараг /задгай, л/	1 800	2 767	153.7
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	25 000	21 867	87.5
	Айраг /л/			
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	6 600	4 550	68.9
	Өндөг /ш/	400	357	89.3
4	Бүх төрлийн өөх тос			
	Ургамлын тос /л/	11 000	10 500	95.5
	Өөхөн тос /кг/	3 000	4 000	133.3
	Шар тос /кг/	25 000	29 000	116.0

	Масло /задгай, кг/	7 500	9 167	122.2
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	2 000	1 767	88.4
	Лууван /кг/	2 500	2 200	88.0
	Манжин /кг/	2 500	3 834	153.4
	Байцаа /кг/	2 000	2 500	125.0
	Сонгино /кг/	2 500	4 334	173.4
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	7 600	8 667	114.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	5 500	5 817	105.8
2. ШАТАХУУН				
	Бензин А - 80	2 480	2 460	99.2
	Бензин А - 92	2 500	2 500	100.0
	Дизелийн түлш	3 730	3 550	95.2

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Терроризмтой тэмцэх зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл нь “Зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмын аюул занал, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх” ажлын хүрээнд мэдээлэл бүхий зурагт хуудас бэлтгэж аймгийн нийт сум, тосгодод хүргүүлсэн.

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын ирүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг сум, агентлагуудад хүргүүлэн саналыг авч хүргүүлсэн.

Авлигын эсрэг хууль тогтоомж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн сургалтыг Алтанбулаг сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллагын удирдлагуудад, Гадаадын иргэн харьяатын газрын Хойд бүс дэх газар, Сүхбаатар сумын 2-р багийн Эрүүл мэндийн төвд тус тус зохион байгуулж, сургалтад нийт 56 албан хаагч хамрагдсан.

Аймгийн Цагдаагийн газар: 2023 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 661 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар буурсан байна. Нийт 5612 гомдол мэдээлэл бүртгэгдэж, үүнээс гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 1624, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 3988 бүртгэгдсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар: 2023 оны 11 дүгээр сард иргэний шийдвэр гүйцэтгэх тасагт 49 гүйцэтгэлийн хуудсыг хаасан. Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээгээр шийтгэгдсэн 24 гүйцэтгэх хуудас ирж, 25 гүйцэтгэх хуудас хааж, 172 гүйцэтгэх хуудсыг хяналтдаа авч ажиллаж байна.

Аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс: 2023 оны 11 дүгээр сард шүүх эмнэлгийн шинжилгээний тоо 121, хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоо 96, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр эд мөрийн баримтын тоо 102, криминалистикийн шинжилгээ 8, цогцост хийсэн шинжилгээний тоо 25, задлан шинжилгээний тоо 16 хийж ажилласан.

Улсын бүртгэлийн хэлтэс: 2023 оны 11 дүгээр сарын иргэний бүртгэлийн талаар

- Төрсний бүртгэл - 126 /эрэгтэй-65, эмэгтэй-61/
- Гэрлэлтийн бүртгэл - 28

- Гэрлэлт цуцалсны бүртгэл - 15
- Үрчлэлт - 4
- Эцэг, эх тогтоолт – 14 /үүнээс эрэгтэй 3, эмэгтэй 11/
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл - 4
- Нас баралт - 63
- Нийт олгосон иргэний үнэмлэх - 326
- Шинээр олгосон иргэний үнэмлэх - 103
- Дахин олгосон иргэний үнэмлэх - 46
- Иргэний үнэмлэхийн хугацаа дуусаж авсан - 172
- Гадаад паспорт олголт - 300
- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн – 115 /үүнээс насанд хүрсэн 78, хүүхэд 37/
- Хот доторх шилжилт хөдөлгөөн - 74 тус тус бүртгэгдсэн байна.

Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн талаар:

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо - 483
- Анхны бүртгэл - 155
- Өмчлөх эрх шилжих гэрээ - 98
- Барьцааны гэрээ - 192
- Бүртгэлд өөрчлөлт оруулах - 18
- Лавлагаа хуулбар - 11
- Нийт бичигдсэн гэрчилгээний тоо – 269

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө, өмчлөх эрхийн улсын бүртгэлийн талаар

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо- 553
- Анхны бүртгэл- 51
- Өмчлөх эрх шилжих гэрээ- 98
- Барьцааны гэрээ- 376
- Бүртгэлд өөрчлөлт оруулах- 15
- Лавлагаа хуулбар-6
- Нийт бичигдсэн гэрчилгээ-163

Архивын тасаг: Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Нээлттэй Сэлэнгэ” арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Архивын ерөнхий газар, Үндэсний төв архивтай хамтран “Сэлэнгэ аймгийн түүхэн баримтууд” сэдэвт архивын баримтын үзэсгэлэнг зохион байгуулж, Сэлэнгэ нутгийн зон олон болон арга хэмжээнд оролцогсдод үзүүлэн танилцуулсан.

Орчин цагийн Архивын алба үүсэн байгуулагдсаны 96 жилийн ойг тохиолдуулан Архивын ерөнхий газартай хамтран зохион байгуулах “Архив, албан хэрэг хөтлөлт” сэдэвт 16 цагийн сертификатын сургалтад хамрагдах ажилтнуудын судалгааг авч, нэгтгэх ажлууд хийгдлээ.

Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагчийн хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Цагдаагийн газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Стандарт, хэмжил зүйн хэлтсийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж,

заавар зөвлөгөө өгч, 32 албан хаагчдад хадгаламжийн нэгж бүрдүүлэх, боловсруулах тухай сургалтыг зохион байгуулсан.

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

Эрүүл мэндийн чиглэлээр:

Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, оношилгоо, эмчилгээнд хамруулах ажлын хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Үүнд:

- Аймгийн хэмжээнд өнөөдрийн байдлаар хүүхдийн 0-17 насны 2 багц үзлэг, оношилгоонд 37981 хүүхэд хамруулахаас 25401 хүүхэд хамруулсан. Хамралтын хувь 66,8 хувь байна. Насанд хүрэгчийн 4 багцын 69918 иргэн хамруулахаас 8468 насанд хүрсэн иргэн хамруулсан. Хамралтын хувь 12,1 хувь байна.
- Эрүүл мэндийн салбарын танилцуулга бүхий хэвлэмэл ном, хөлтэй самбар болон QR кодтой цахим танилцуулга наалтыг шоколадны гадна цаас, цэвэр усны саванд байршууллаа. Мөн салбарын хэмжээнд хийсэн томоохон ажил, хүний нөөцийн хангалт, дутагдлын мэдээлэл, бүх шатны байгууллагын танилцуулга зэргийг агуулсан мэдээллийг иргэдэд хүргэж ажилласан. “Нээлттэй Сэлэнгэ” арга хэмжээнд эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг нэмэгдүүлэх талаар танилцуулга мэдээллийг нийт 260 хүнд хүргэж ажилласнаас хөдөө орон нутаг ажиллах хүсэлтэй 2 эмч анкет бөглөж судалгаанд хамрагдсан байна.
- “Өсвөр үеийнхэнд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх” кабинет шинээр байгуулж, 11 дүгээр сарын 08-ны өдөр нээлтээ хийлээ.

Боловсрол, шинжлэх ухааны чиглэлээр:

Хүүхэд багачууд, иргэдэд хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна. Үүнд:

- 2023-2024 оны хичээлийн жилийн 2 дугаар улирлаас эхлэн ЕБС-ийн 3, 4 дүгээр ангийн Математикийн хичээлээр хэрэгжүүлэх “Эдүтэн”, 5-6 дугаар ангийн англи хэлний “Pearson” хөтөлбөрийн цахим платформын туршилтын үйл ажиллагаа болон сургуулийн бэлэн байдал, анги танхим, тоног төхөөрөмж, интернэтийн хүчин чадлын нөхцөл байдал, боломжийг судлан мэдээлэл цуглуулж, 8 сургууль дээр ажиглалт, мониторинг хийж ажиллалаа. Энэхүү платформыг сургалтын явцад хэрэгжүүлж эхлэхээс өмнө БҮТ-өөс ирүүлсэн даалгавар, удирдамжийн дагуу ЕБС-ийн 3,4 дүгээр ангийн сурагчдын Математикийн хичээлийн гарааны үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, нийт 4300 гаруй сурагчийг хамрууллаа.
- "SCIENCE FAIR 2023" улсын уралдаан Улаанбаатар хотод 2023.11.11-нд зохион байгуулагдахад Сэлэнгэ аймгийн сурагчдаас 10, 11, 12 дугаар ангийн ангилалд сурагчид өөрсдийн бүтээлээр оролцлоо.
- “Бэлгийн цогц боловсрол”-ын агуулгыг хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг 2023 оны 11 дүгээр сарын 22-24-ний өдрүүдэд зохион байгуулахад Боловсролын ерөнхий газар, Нийслэлийн боловсролын газар, 21 аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын Биологи, эрүүл мэндийн судлагдахуун хариуцсан мэргэжилтнүүд, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн багш нарын хамт сургагч багшаар бэлтгэгдэж байна.

- “Дэлхийн тогооч нар”-ын өдрийг тохиолдуулан тогооч нарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага судлах, ажил мэргэжлийн онцлогийг олон нийтэд сурталчлах зорилго бүхий үзүүлэн ажил болон 3 төрөлт спортын тэмцээнийг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, политехник коллежийн тогооч нарын дунд зохион байгуулж нийт 187 тогооч нар идэвхтэй оролцлоо.

Соёл урлагийн чиглэлээр:

Хүний хөгжилд соёл урлагийн үр нөлөөг нэмэгдүүлэх, соёл уламжлалаа дээдлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулан ажилласан байна. Үүнд:

- “Нээлттэй Сэлэнгэ түмэн” өдөрлөгт Соёл, урлагийн газрын дарга, мэргэжлийн урлагийн 2 байгууллагын уран бүтээлчид оролцлоо.
- “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд яамнаас цахимаар зохион байгуулсан чиглэлийн 7 сургалт, Улаанбаатар хотноо танхимын 1 форумд соёл урлагийн газрын мэргэжилтэн, ажилтнууд хамрагдлаа. Соёлын бүтээлч үйлдвэрлэл, Бүх нийтийн Соёлын боловсрол, Соёлын эрхийн бичиг, Соёлын өвийн хадгалалт хамгаалалт сэдвүүдээр 4 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 180 гаруй хүнийг хамруулсан байна.

Хүүхэд залуучууд гэр бүлийн чиглэлээр:

Гэр бүл, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих, тэднийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулсан байна. Үүнд:

- Хүүхдийн өөрийн сонирхолд тулгуурласан, хүүхдийн оролцоог дэмжсэн, чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх, авьяас чадвараа нээн илрүүлэх зорилгоор Мандал сум дахь Хүүхдийн ордны 5 төрлийн дугуйланд 119 хүүхэд, Орхонтуул Хүүхэд хөгжлийн төвийн 6 төрлийн дугуйланд 34 , байгууллагын дэргэдэх 2 төрлийн дугуйланд 13, нийт 166 хүүхэд хамрагдсан.
- Хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэхэд хүүхдийн өмнө үүрэг хүлээгчид, эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг оролцоо нэн чухал, тэдгээрийг татан оролцуулах зорилгоор зохион байгуулж, хүүхдийн эрүүл орчинд амьдрах эрхийг хангахыг зорилтын хүрээнд эцэг, эх, асран хамгаалагч, байгууллага, аж ахуйн нэгжүүд дараах байдлаар амьдрах газар, орчиндоо аюулгүй байдлын үнэлгээ хийж, орчны эрсдэлийг бууруулах, арилгах арга хэмжээ авсан.
- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээлэл түгээж хүчирхийллээс татгалзах, эерэг хандлагад уриалан бага насны 450 хүүхэд, ахлах ангийн 338 хүүхэд, 0-18 насны хүүхэдтэй нийт 178 эхэд сургалт зохион байгууллаа. Хүүхдэдээ тавих анхаарал, халамжийг нэмэгдүүлэх зорилготой бага насны хүүхэдтэй 500 эцэг эхэд “Мундаг аав ээжийн өөрийгөө дүгнэх хуудас” түгээж ажиллалаа.
- “Бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь”, “Бэлгийн боловсрол” олгох сэдэвт сургалтыг Цагдаагийн газартай хамтран нийт 7 ЕБС-ийн ахлах ангийн 127 хүүхэд, 140 эцэг эх нийт 267 иргэнд зохион байгууллаа. Сургалтын үр дүнд өсвөр насны хүүхдийн бие физиологийн онцлог, шилжилтийн нас, бэлгийн замын халдварт өвчин, гэмт хэрэг зөрчлийн талаарх ойлголт, хөхний хорт хавдар, түрүү булчирхайн хорт хавдар, бэлгийн хүчирхийллээс

урьдчилан сэргийлэх арга зам, ойлголт, мэдлэгийг нэмэгдүүллээ. Мөн тус аяны хүрээнд аяны постер, зураг, видео шторкийг байгууллагын цахим хуудас, 17 сумдын цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 3024 гаруй эцэг эх асран хамгаалагчдад мэдээлэл хүргэсэн.

- Залуучуудын явуулын үйлчилгээгээр 7 сум 1 тосгонд ажиллаж Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч, цахим залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааг сурталчлан таниулж, 820 сурагчдад амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалтыг зохион байгууллаа.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, даатгал чиглэлээр:

Иргэний аж ахуй эрхлэх ур чадварыг хөгжүүлж, дэмжлэг үзүүлэн ажилтай орлоготой болгох зорилтын хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна. Үүнд:

- “Нээлттэй Сэлэнгэ” арга хэмжээнд оролцож, аймгийн хэмжээнд нээлттэй зарлагдсан 300 гаруй сул чөлөөтэй ажлын байрыг иргэд олон нийтэд мэдээлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн талаарх мэдээллийг танилцуулж ажиллалаа.
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон албан бус салбарт ажиллаж буй залуучууд, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагч 15-34 насны 120 иргэнд зориулсан сургалтыг “Бэст метод” ХХК-ны дэргэдэх Бэст инновац сургалтын байгууллагатай хамтран 2023 оны 11 дүгээр сарын 09-10-ны өдрүүдэд зохион байгууллаа.
- Түшиг, Ерөө, Жавхлант, Хүдэр, Алтанбулаг, Шаамар зэрэг сумдад ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ арга хэмжээ зохион байгуулагдаж эрүүл мэнд, боловсрол, архив албан хэрэг хөтлөлт, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн салбарт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн 7 ахмад настныг түр ажлын байраар ханган өрхийн орлогыг нь нэмэгдүүлэн ажиллалаа.
- Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд нийтийг хамарсан ажил арга хэмжээг Сайхан, Мандал, Сүхбаатар, Сант, Хүдэр зэрэг суманд зохион байгуулж нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижуулах, зам засвар, ногоон байгууламжийн хашаа барих ажилд зорилтот бүлгийн 42 иргэнийг түр ажлын байраар хангалаа.
- “Хөгжлийн бэрхшээлд хаалгаа нээе” өдөрлөг, үзэсгэлэн худалдааг 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулж, “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны танилцуулга”, Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйл “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт” сэдвээр сургалт мэдээллийг хүргэн ажилласан. Хөгжлийн бэрхшээлтэй 20 иргэний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчлан борлууллаа.

Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр:

Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль болон холбогдох хууль тогтоомж тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар сумдын хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэгч нарт 2023 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр “Хүнсний аюулгүй байдлын хангуулах, зохистой дадлыг хэвшүүлэх,

дотоод хяналтыг сайжруулах”, Хоол үйлдвэрлэлийн байранд эрүүл ахуйн зохистой дадал”, “Бэлгийн замаар халдах өвчний өнөөгийн байдал”, “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай”, “Галын аюулгүй байдлыг хангах”, “Е баримт олголт”, “Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газарт тавих шаардлага”, “Эрүүл зөв хооллолт” сэдвээр батлагдсан хөтөлбөрийн хүрээнд сургалтыг зохион байгуулж, нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 43 иргэн аж ахуйн нэгж хамрагдлаа.

Аймгийн хэмжээнд 17 сумын 57 багийн 9884 малчин болон мал бүхий өрхөд 2 сая толгой мал өвөлжиж байна. Мал сүргийн 97 хувь нь дунд ба дундаас дээш тарга хүч авсан. Улсын тусгай хамгаалалттай газар болон хилийн зурвас газарт 68,5 мян.мал бүхий 305 өрх өвөлжихөөр байна. Малын хашаа, байр засах, уст цэгийг лайдах, засварлах, өтөг бууц, түлээ түлш бэлтгэх ажлыг малчид, мал бүхий аж ахуйн нэгж, байгууллага 100 хувийн гүйцэтгэлтэй бэлтгэл ажлыг ханган ажиллалаа.

Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 150 тн өвс, 30 тн тэжээл бэлтгэхээс 30 тн тэжээлийг Алтан тариа ХХК-тай гэрээ байгуулан цаг хүндэрсэн үед малчдад нийлүүлэхээр болсон. Сумдын нөөцөд 1020 тн өвс, 680 тн тэжээл бэлтгэхээс 825 тн өвс, 460 тн тэжээл бэлтгэсэн нь 65,9 хувьтай байна. Тэжээлийн нэгжид шилжүүлснээр аймгийн хэмжээгээр 116.9 сая т.н бүхий тэжээл бэлтгэсэн нь нэг хонин толгойд 32.4 т.нэгж ноогдож байна. 108,1 мянган толгой мал байнгын, 331,3 мянган мал нэмэгдэл тэжээлтэй өвөлжих бөгөөд эдгээрт шаардагдах тэжээлийг бэлэн байгаа тэжээлтэй харьцуулахад тэжээлийн хангамж 100 хувьтай байна.

2023-2024 оны өвөл, хавар бэлчээрт 4196 инженерийн хийцтэй болон энгийн уурхайн худаг ашиглагдах бөгөөд худгийн бэлэн байдал 97,6 хувь, өрхийн усан хангамж 96,2 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд мал өвөлжилтийн бэлтгэл бэлэн байдлыг 92,8 хувийн гүйцэтгэлтэйгээр хүлээн авч Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.

Хадлан бэлтгэх ажилд аймгийн хэмжээгээр том болон бага оврын 1197 трактор, 953 хадуур, 762 тармуур, 270 хаман боогч ажиллаж 160.9 мянган тн байгалийн хадлан, 46,5 мян.тн хүчит тэжээл, 5,8 мян.тн эрдэс тэжээл бэлтгэхээс 165.5 мян.тн өвс, 1000 тн сүрэл, 14.4 мянган тн ногоон тэжээл, 34.5 мянган тн үйлдвэрийн тэжээл, 5.5 мян.тн дарш, 80 тн гар тэжээл, 3.9 мян.тн эрдэс тэжээл бэлтгэсэн нь малчин болон мал бүхий иргэдийн түвшинд бэлтгэх өвс, тэжээлийг 97.2 хувьтай бэлтгээд байна. Өөрийн аймгийн болон бусад аймгийн иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас өөрийн хэрэгцээ болоод бизнесийн зориулалтаар 21,1 мян.тн өвс, 2,8 мянган тн ногоон тэжээл бэлтгэснээс 12,9 мян.тн байгалийн хадлан, 1,3 мянган тн ногоон тэжээлийг борлуулж одоогийн байдлаар үлдэгдэл байгалийн хадлан 5,1 мянган тн, ногоон тэжээл 4,5 мян.тн байна.

Мал эмнэлгийн чиглэлээр:

“Бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, сорил шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах тухай” захирамжийн хүрээнд мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж, технологит хугацаанд хэрэгжүүлж байна.

Сүхбаатар сумын хэмжээнд хүнсний зах дэлгүүрт худалдан борлуулж байгаа мах махан бүтээгдэхүүний 13680 кг үхрийн махны 114 дээж, 1140 кг адууны 16 дээж, 462 кг хонины махны 22 дээж, 220 кг ямааны махны 11 дээж, 180 кг сүү, сүүн

бүтээгдэхүүний 5 дээж ариун цэврийн магадлан шинжилгээг стандарт арга зүйн дагуу хийж гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөт шинжилгээнд сүрьеэгийн харшил сорил шинжилгээнд 1200 толгой үхэр, адууны ямын харшил сорил шинжилгээнд 1200 толгой адуу хамрагдаж дууссан.

Аймгийн хэмжээнд зарим халдварт өвчнийг илрүүлэх болон өвчингүй, тайван байдлыг баталгаажуулах тандалт шинжилгээнд 17 сумын 1466 өрхийн 4398 сорьц дээжийг хамруулсан.

Мал эмнэлгийн газраас ХААИС, МЭС-ийн оюутан залуус болон нийслэлийн ард иргэд 350 гаруй хүнд 100 жилийн түүхт Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн салбарын мэдээ мэдээлэл, танилцуулга, урилгыг хүргэн ажиллалаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:

“Тэрбум мод” аяны хүрээнд зарласан болзолт уралдаанд Мандал сумаас 2, Цагааннуур сумаас 5, Шаамар сум 3 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага материалаа ирүүлсэн бөгөөд ирүүлсэн материалуудад үнэлгээ хийж байна.

Мод бэлтгэлийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний шалгалтыг Алтанбулаг, Түшиг, Цагааннуур, Хүдэр, Мандал сумдад Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын удирдамжийн дагуу эрхийн бичиг олголт, талбай тусгаарлалтын ажил, хот хооронд тээвэрлэлт хийсэн гарал үүслийн эрхийн бичигт мониторинг шалгалт хийж, аймгийн хэмжээнд гүйцэтгэл 41 хувьтай байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төвийн хэрэгжүүлж буй “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги төлөвлөлтийг боловсронгуй болгох, орон нутгийн иргэдийн байгаль орчин болон байгалийн нөөцийн салбарт дасан зохицох чадавхыг бэхжүүлэх төслийн хүрээнд танилцуулга уулзалтыг 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын их танхимд зохион байгуулагдаж 30 албан хаагч хамрагдлаа.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр:

Сумдын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр батлагдсан газар эзэмших эрхийн дуудлага худалдааг Шаамар, Сайхан, Жавхлант сумдад зохион байгуулж, Алтанбулаг, Сант, Орхонтуул, Хүдэр, Түшиг, Мандал, Баянгол сумдад зохион байгуулах дуудлага худалдааны зарыг газрын цахим бирж болон Зууны мэдээ сонинд байршуулан ажиллалаа.

Алтанбулаг, Цагааннуур, Түшиг, Орхонтуул, Орхон, Баруунбүрэн сумдад байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар болон мод бэлтгэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын өөрийн хөрөнгөөр 2023 онд хийсэн ойжуулалтын ажлын гүйцэтгэлийг шалгаж хүлээн авах ажлын хэсэгт хамтарч ажиллалаа.

Зургаа. Сум, орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум

УИХ-ын гишүүн Ч.Ундрамын нэрэмжит Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “SELENGE LEAGUE 2023” сагсан бөмбөгийн тэмцээн 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгууллаа.

Улс тунхагласны баярыг тохиолдуулан “Иргэний андгай” өргөх арга хэмжээг 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Ерөнхий Боловсролын сургуулийн 11 дүгээр ангийн нийт 36 сурагчдыг хамруулан зохион байгуулсан.

“Хамтдаа шалгая хамгаалъя” арга хэмжээний хүрээнд эцэг эх, асран хамгаалагч нарт зориулж мэдээ мэдээлэл, эрсдэлийн үнэлгээг цахимаар явуулж байна.

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Нутгийн зөвлөл “Идэвхтэй хөдөлгөөнөөр эрүүл мэндээ дэмжье” өдөрлөгийг сумандаа 2023 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулсан.

“Ногоон гэрэл цагаан шугам 2023” аймгийн уралдаан зохион байгуулсан. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд зохиогдсон “Зохист аялгуу” богино өгүүллэгийн наадамд О.Мягмарцэцэг багштай О.Лхагва-Эрдэнэ сурагч Тусгай байр эзэлсэн.

“I’m brick” олон улсын хөтөлбөрийн сургалт Сэлэнгэ аймгийн түшиц цэцэрлэг дээр зохион байгуулагдаж “Найрамдал” 1 дүгээр цэцэрлэгийн багш арга зүйч нар оролцсон.

“Шагай наадгай бидний өв соёл” аяны хүрээнд сургуулийн өмнөх боловсролын ахлах, бэлтгэл ангийн хүүхдүүдийн дунд “Морь уралдуулах” тэмцээнийг зохион байгуулсан.

“Сүрьеэгүй Сэлэнгэ” арга хэмжээний хүрээнд сумын эрүүл мэндийн төвд “Хиймэл оюун ухаанд суурилсан рентген оношилгоо” 2023 оны 11 дүгээр сарын 06-07-ны өдрүүдэд хийгдсэн.

2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр төр төсвийн байгууллагуудын дунд “Алтан лийр 2023” арга хэмжээг зохион байгуулсан.

Баруунбүрэн сум

Сумын хэмжээнд 24 аж ахуй нэгж, 15 иргэн 11200 га талбайд уриншийн боловсруулалт хийж энэ онд 11148 га талбайд улаан буудай, 80 га талбайд овьёос, 50 га талбайд вандуй, 609 га талбайд тэжээлийн ургамал, 3383 га талбайд тосны ургамал тариалсан. 2023 онд сумын хэмжээнд 534 өрхөд 204637 толгой мал буюу тэмээ 43, адуу 13198, үхэр 21067, хонь 106578, ямаа 63750 толгой хонин толгойд шилжүүснээр 382962 толгой мал өвөлжих тооцоо гарсан бөгөөд өвөлжилтийн бэлтгэл 85 хувьтай байна. Нийт 11547 тонн өвс, 3800 тонн тэжээл, 320 тонн хужир шүүг бэлтгээд байна.

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” аяны хүрээнд 6-12 дугаар ангийн сурагчдын дунд “АХА” тэмцээн болон “Хүчирхийллээс хэрхэн найздаа туслах вэ?” захидлын уралдаан зохион явууллаа.

Угийн бичиг хөтлөх гарын авлагыг 390 иргэнд тарааж анхан шатны мэдлэг олгох, 3 үеийг нь мэдүүлэх удам судрыг нь ярилцах, зурган хэлбэрээр таниулах сургалтыг 2-5 дугаар ангийн 8 бүлгийн нийт 231 хүүхдэд зохион байгууллаа.

“Эрүүл хүүхэд - Эрүүл ирээдүй” аяны хүрээнд эрүүл мэндийн төв нь 1-5 дугаар ангийн 285 гаруй хүүхдийг үзлэг оношилгоонд бүрэн хамрууллаа.

Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалахад төр, хувийн хэвшил, иргэнийг оролцоог нэмэгдүүлэх үүднээс Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг орон нутагт Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын холбогдох мэргэжилтэнтэй хамтран ажиллалаа. Хүүхдийг орчны эрсдэлээс урьдчилан сэргийлэх “Хамтдаа шалгая, хамгаалъя” арга хэмжээг зохион байгуулан, аяны хүрээнд сумын төвд хүүхдэд эрсдэлтэй байгаа газрыг баримтжуулан авлаа.

“Зөв монгол хүүхэд - Бидний ирээдүй” хүүхдийн чуулганыг “Оролцъё, Хөгжье, Хамгаалуулъя” уриа дор зохион байгууллаа.

Хүүхдийн чуулганд Ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн 248 хүүхэд хамрагдлаа. Чуулганыг хүүхдийн эрхийн тухай хуулийг сурталчлах, хүүхдийн дуу хоолойг сонсож хүүхдээс гаргасан санал, санаачилгыг дэмжиж ажиллах, хүүхдийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, өөрийгөө нээн илэрхийлэх зорилготой зохион байгууллаа.

Баянгол сум

“Зөв Монгол хүүхэд -Бидний ирээдүй” хүүхдийн чуулганыг зохион байгуулж, Баянгол сумын ЕБС-ийн 6-12-р ангийн нийт 515 сурагч хамрагдаж, “Хүүхдийн эрхийн тухай”, “Зөв хүүхэд гэж хэн бэ?” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

2023 оны 11 дүгээр сарын 22 зохион байгуулсан “Мэргэжил сонголт-ОХУ” арга хэмжээнд 12-р ангийн сурагчид оролцлоо.

“Золбин нохой муур устгах ажлыг зохион байгуулах тухай” захирамжийн хүрээнд багийн засаг дарга нар болон иргэн Ганбаатартай хамтран нохой устгалын ажлыг хийж нийт 23 нохойг устгаж хот тохижилтын албан хаагчидтай хамтран сумын төв хогийн цэгт булшилж, зургаар баримтжуулан мэдээ тайланг гаргаж ажилласан.

Хяналт шалгалтаар Баянгол сумын нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагуудад хяналт шалгалт хийж үйл ажиллагаатай танилцаж техникийн нөхөн сэргээлт болон биологийн нөхөн сэргээлтийг эрчимжүүлэх талаар заавар зөвлөгөөг өгч ажилласан.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, байгалийн гэнэтийн гамшиг осолтой тэмцэх урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ой хээрийн түймрээс сэргийлэх санамж бичиг, зурагт хуудсыг Баянгол сумын байгаль орчин, аялал жуулчлалын газрын цахим хаягт байршуулан сурталчилж байна.

Өргөн хэрэглээний гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөцийг 7 хоног бүр тодорхойлж бүтээгдэхүүний хүрэлцээг тогтвортой байлгах, нөөц бүрдүүлэлт, дэлгүүрийн үйл ажиллагаанд хяналт тавих, өргөн хэрэглээний гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөцийн судалгааг 7 хоног бүр ХХААХҮЯ-ын программд шивж байна.

Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Нээлттэй Сэлэнгэ” арга хэмжээнд сумын брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 1 аж ахуй нэгж, 1 хоршоо, 5 иргэн амжилттай оролцсон.

Ерөө сум

Мал эмнэлэг, үржлийн албаны 100 жилийн ой, Ерөө сум үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойг угтан малчдын дунд 3 төрөлт спортын арга хэмжээг амжилттай зохион байгуулж, 8 хэсгийн 100 гаруй малчид хамруулсан бөгөөд малчдын өрхийн үйлдвэрлэлийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан.

Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Захирагчийн албатай хамтран Бугант тосгонд зөөврийн төхөөрөмж ашиглан “Явуулын баг” эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулан ажиллалаа.

2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэлийн ажлын хүрээнд сумын хэмжээнд 650 гаруй малчин, мал бүхий өрх 12800 тн хадлан бэлтгэж, 75 тн өвс, 10 тн тэжээлийн будааг нөөцлөөд байна

"Стрептококкийн халдвараас сэргийлэх эрт илрүүлэх, үзлэг оношилгоо"-г 10 дугаар сарын 30-аас эхлүүлж, Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн 748 хүүхдийг 100 хувь хамруулсан.

Дархлаажуулалтын үндэсний товлолын дагуу хүүхдийн сахуу, татрангийн дархлаа сэргээх дархлаажуулалтыг 7 настай 87 ,15 настай 128 нийт 215 хүүхдэд хийсэн.

Эцэг эх асран хамгаалагчид, олон нийтэд байгууллагуудад "Хамтдаа шалгая, хамгаалъя" арга хэмжээг сурталчлан таниулах зорилгоор 1 шторк хийж 122 хүнд, ГБХЗХГазрын мэдээллүүдийг цахим орчинд нийтэлж 356 хүнд хүргэж ажилласан.

"Хамтдаа шалгая, хамгаалъя" сэдэвт зурагт хуудсыг 84,000 төгрөгийн өртөгтэйгөөр хэвлүүлэн 3 самбарт 3 байршилд байрлуулан иргэд олон нийтэд сурталчилсан.

ЕБСургууль, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын баг 21 багц судалгааг шинэчлэх ажлыг хийж гэр сургууль гэр маршрутыг зураглал гарган гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөн ажиллалаа.

Жавхлант сум

Боловсролын ерөнхий газраас "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ын хүрээнд бүх нийтэд Монгол бичгийг сургах, иргэдийн Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор Хэлний салбар зөвлөл хамтран үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Төрийн албан хаагчийн өдөрлөг" арга хэмжээ 3 төрөлтэйгөөр зохион байгууллаа.

Аймаг, сумын Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэн "МОНГОЛ ХҮҮХЭД - МОНГОЛ БАХАРХАЛ" Ерөө бүсийн хүүхдийн язгуур урлагийн наадам амжилттай зохион байгуулагдлаа.

Хамтарсан багийн зүгээс "Хамтдаа шалгая, хамгаалъя" аяны хүрээнд эцэг, эх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоотойгоор хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, ахуйн осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх орчны эрсдэлийг үнэлж, өөрийн гэр, албан байгууллагын дотоод, гадаад орчны эрсдэлийн үнэлгээг хийх, илэрсэн эрсдэлийг арилгах зорилгоор хамтран ажиллаж байна.

"СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР" аяны хүрээнд Сэлэнгэ аймгийн сумдын Соёлын төвийн дарга нар, орон нутгийн соёлын төвийн ажилтнуудын дунд "Музейн боловсрол-угсаатны өв соёлыг нутагшуулан хөгжүүлэх нь" сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж салбарын хууль тогтоомж, эрх зүйн бодлого зорилтын хүрээнд мэдлэг олгон арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаа.

Сэлэнгэ аймагт НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгээр хэрэгжиж буй "Сургуулийн насны хүүхдүүдийн дунд стрептококкийн халдвар илрүүлэх үзлэг оношилгоо"-г сумын хэмжээнд амжилттай зохион байгуулж, 1-5 дугаар ангийн 152 хүүхдүүдийг 100 хувь хамрууллаа.

Насан туршийн боловсролын нэгжийн үндсэн чиглэл болох эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгох ажлын хүрээнд ЕБС-н дотуур байрны суралцагчдад "Томуу, томуу төст өвчин, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх " сургалт мэдээллийг хүргэлээ.

Зүүнбүрэн сум

“Хамтдаа шалгая, хамгаалъя арга хэмжээ”-ний хүрээнд сумын хамтарсан багийн гишүүд, амьдарч буй орчин, оршин суугаа газрын аюулгүй байдлын үнэлгээ, хүүхдийн гэрээс сургууль, цэцэрлэг хүрэх замын аюулгүй байдалд үнэлгээ, төр, төсвийн байгууллага, аж ахуй нэгж, байгууллагуудын гадна болон дотно талбайд хүүхдийн ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх орчны эрсдэлийн үнэлгээг хийж, 1-5 дугаар ангийн багш нар гэр айлчлалын хүрээнд ангийн сурагчдын нийт 37 айл өрхөөр орж заавар зөвлөгөө өгч, гарын авлага тараан ажилласан.

Сумын хэмжээнд 2023 оны ургац хураалтын ажил 100 хувь дуусаад байна. 2023 онд улаанбуудай 16267 тн, арвай 1166 тн, овьёос 536 тн, эрдэнэшиш 1600 тн, ногоон тэжээл 825 тн, рапс 2182 тн, төмс 210 тн, хүнсний ногоо 3850 тн хураан авч, улаанбуудай 16267 тн хураан авснаас үрэнд 1026 тн, тэжээлд 855,5 тн, дотоодын гурилын үйлдвэрүүдэд 11385,5 тн, борлуулагдаагүй үлдэгдэл 3000 тн байна.

“Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх намрын дархлаажуулалтыг зохион байгуулах” ажлын хүрээнд сумын ажлын хэсэг байгуулан 432 өрх, 1 аж ахуйн нэгжийн 20100 толгой үхэр, 400 толгой гахай нийт 20500 толгой мал, амьтныг дархлаажуулалтад хамрууллаа.

Цагааннуур суманд ГАМ өвчний шинж тэмдэг илэрч Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторийн шинжилгээний 23-6819 бүртгэлийн дугаар бүхий дүнгийн хуудсаар баталгаажсан тухай зөвлөмж, чиглэлийн дагуу, иргэдэд гахайн гоц халдварт өвчний талаар сэрэмжлүүлэг, зөвлөмж, гахайн африкийн мялзан, цусан халдвар-иж балнад зэрэг халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гахайг байнгын байранд маллагаанд байлгах талаар мэдэгдэл өгч хоолны газрын хоолны хаягдал үлдэгдлээр гахайгаа тэжээхгүй байх талаар зөвлөмж хүргэж ажиллалаа.

“Илдэн бүрэн” ОНӨААТҮГ нь өвөлжилтийн бэлтгэл, сумын төр, төсвийн байгууллагын дулааныг тасралтгүй хангах ажлын хүрээнд “Улаан Овооны нүүрсний уурхай”-аас 100 тн нүүрсийг татан төвлөрүүллээ.

Мандал сум

Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын арга хэмжээг орон нутагтаа зохион байгуулж төрийн албаны тусгай шалгалтад тэнцсэн 6 төрийн захиргааны албан хаагч 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр тангаргаа өргөлөө.

Цагдаагийн байгууллага, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран цахим орчинд үйлдэгдэж буй хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, мэдээллийн технологийн зохистой хэрэглээг бий болгох, зорилготой “Нууцалъя - Private” нөлөөллийн аянд төрийн болон төрийн бус байгууллагын 30 гаруй байгууллага нэгдлээ.

“Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-г 2023 оны 10 дугаар сарын 4-өөс 12 дугаар сарын 31 хүртэл улс, орон даяар зохион байгуулагдаж байна. Үндэсний статистикийн хороо нь статистикийн тухай хуульд заасны дагуу “нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-г НҮБ-ын хүүхдийн сан, НҮБ-ын хүн амын сантай хамтран гурав дахь удаа зохион байгуулж байна. Манай сумаас 100 өрх хамрагдаад байна.

2023.11.08-ны өдөр УИХ-н гишүүн Хүн намын дарга Т.Доржханд Мандал сумын ард иргэдтэй уулзалт зохион байгууллаа. Тэрээр “ Сумаа өрөөс чөлөөлье ” хөтөлбөр, “Төр сумдын түншлэлийн батламж” зэрэг ойлголтуудын хүрээнд мэдээлэл хүргэн санал солилцсон юм.

“Хамтдаа шалгая, хамгаалъя” аянд нэгдэж сумын цахим хуудсанд аяны талаарх мэдээлэл, зурагт хуудсыг байршуулж эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид, албан байгууллагуудыг нэгдэхийг уриалж, аяны талаарх мэдээллийг түгээж ажиллалаа. Аянд тус сумын төр төсвийн 16 байгууллага болон 17 хувийн хэвшил нэгдэж тус бүр албан байгууллагын орчны үнэлгээнд хамрагдаж, ажилчин, албан хаагчид ахуйн үнэлгээг өөрийн орон сууц, гэртээ хийлээ.

Сумын хүүхэд хамгааллын хамтарсан багийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд Ом-Тара уламжлалт анагаах ухааны эмнэлгийн их эмч, АУ-ны магистр О.Очгэрэлийг урин авчирч Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоо үйлчилгээг 2023 оны 11 сарын 11, 12-ны өдрүүдэд Хэрх эрүүл мэндийн төвийн байранд зохион байгууллаа. Уг үзлэгт хөгжлийн бэрхшээлтэй 70 хүүхдийг хамруулж эмчилгээ бичиж, зөвлөгөө өглөө.

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүд, хүүхэд хамгааллын Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалт 2023 оны 11 сарын 23-ны өдөр зохион байгуулагдаж хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 18, хамтарсан багийн 40 нийт 58 албан хаагчид оролцлоо.

Мандал 3 дугаар сургуулийн “Хүмүүнлэг сурагчид” клубээс санаачлан сумын улаан загалмайн анхан шатны хороо хамтран “Халуун дулаан сэтгэл” аяныг өрнүүлж, тус сургуулийн 97 багш, ажилчид болон 40 бүлгийн 1200 гаруй сурагчид нэгдэн мандал сумын малчин иргэддээ туслах зорилготойгоор дулаан бээлий, дулаан оймс, гар чийдэн, лаа, чүдэнз зэргийг цуглуулан Улаан загалмайн анхан шатны хороонд хүлээлгэн өглөө.

Бага насны хүүхдийг зам тээврийн осол, хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, тэдэнд замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд аюулгүй зөв оролцох дадал эзэмшүүлэх зорилгоор сумын цагдаагийн хэлтэс, замын цагдаагийн алба, сумын ГХУСАЗС зөвлөл хамтран “Ногоон гэрэл, цагаан шугам” арга хэмжээг сумын ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын дунд зохион байгууллаа.

Европын Холбоо, ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн яам (BMZ)-ны хамтарсан санхүүжилттэйгээр хэрэгжиж буй “Хөдөө ахуйн менежмент, экосистемийн тогтвортой байдлыг хангах “STREAM” төсөлтэй хамтран “Мод бэлтгэлийн ажлын-Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй” сэдэвт онол, практик хосолсон сургалтыг 11 дүгээр сарын 20, 21, 22-ны өдрүүдэд Мандал суманд зохион байгуулж, нийт 17 аж ахуй нэгж байгууллагын 20 хүн албан хаагч хамрагдлаа.

Орхон сум

Сумын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд малчин, мал бүхий 380 иргэнтэй 2542 га талбайд малын өвс, 203 иргэнтэй 3500 га талбайд бизнесийн зориулалтаар хадлан бэлтгэх гэрээ байгуулсан ба сумын аюулгүйн нөөцөд 2063 боодол буюу 41.3 тн өвсийг бүрдүүлээд байна. Сумын аюулгүйн нөөц бүрдүүлэлт 68.8 хувьтай байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй “Эрүүл хүүхэд-Эрүүл ирээдүй” аяны хүрээнд “Стрептококкийн” буюу гүйлсэн булчирхайн халдварыг эрт илрүүлэх үзлэг оношилгоонд ерөнхий боловсролын сургуулийн 1-5-р ангийн 128 сурагчийг хамрууллаа.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Хөдөөгийн сэргэлт” хөтөлбөрийн хүрээнд “Нээлттэй Сэлэнгэ” арга хэмжээ Улаанбаатар хотноо 11 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Тус сумаас хүнсний ногоо, утсан загас, сүү сүүн бүтээгдэхүүний чиглэлээр 3 иргэн оролцлоо.

Мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд иргэд, олон нийтэд цаг үеийн мэдээ мэдээллийг фото мэдээлэл, шторк, сурталчилгаа хэлбэрээр “Сэлэнгэ Орхон сум ЗДТГ”, “Сэлэнгэ аймгийн Орхон сум”, “Нарт Орхоны хүүхдүүд”, “Selenge Orhon Emt” зэрэг албан ёсны фейсбүүк хаягуудад байршуулан 15 удаагийн мэдээ мэдээллийг хүргэж, давхардсан тоогоор 420 хүний хандалтыг авсан байна.

“Ерөнхий боловсролын сургуульд хамрагдалтыг илрүүлэх” 6-18 насны хүүхэдтэй 264 өрхийг хамрууллаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас “Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ”-г үзүүллээ. Үүнд:

- “Хүүхдийн эрхийн хэрэгжилт өнөөгийн нөхцөл байдал” сэдэвт сургалт
- “Гэр бүлийн үнэ цэнэ ба аз жаргал” сургалтад 22 иргэнийг хамрууллаа.

Мөн мэргэжлийн сэтгэл зүйч ажиллаж 3 эцэг эх, 6 хүүхэд зөвлөгөө өглөө.

Хүүхдийн ахуйн осол гэмтэл, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, орчны эрсдэлийг бууруулах чиглэлээр “Хамтдаа шалгая, хамгаалъя” арга хэмжээг 10 дугаар сарын 26-аас 11 дүгээр сарын 24-ний өдрийн хооронд улсын хэмжээнд зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 5 төр, төсвийн байгууллага нэгдэж, 9 зөрчил илрүүлснээс 8 арилган ажиллалаа.

“Угийн бичгээ хөтөлж-Ураг удмаа мэдэцгээе” аяны хүрээнд 3 төр, төсвийн байгууллагын 72 төрийн албан хаагч оролцлоо. “Угийн бичиг хөтлөх арга зүйн сургалт”-ыг байгууллага бүр ажилчдадаа зохион байгуулж, 30 албан хаагч хамрагдлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг угтан “Хөгжлийн бэрхшээлд хаалгаа нээе” өдөрлөг, үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, 23 иргэн оролцлоо.

Сумын хэмжээнд 2023 онд нийт 11966 га талбайд тариалалт хийснээс улаан буудай 8239 тн, овьёос 72 тн, арвай 12 тн, тэжээлийн ургамал /судан өвс/ 997 тн, тосны ургамал 1601,5 тн, төмс 9000 тн, хүнсний ногоо 15588 тн-ийг тус тус хураан авлаа.

“Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх намрын дархлаажуулалтыг зохион байгуулах” ажлын хүрээнд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 362 өрхийн 19630 үхэр, 12 өрхийн 385 гахайг хамрууллаа.

Орхонтуул сум

Орхонтуул ЗДТГ, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сум фейсбүүк, Рашаант тосгон зарын групп, Рашаант тосгон захирагчийн алба фейсбүүк болон Orkhontuul.se.gov.mn веб сайтад 12 төрлийн урьдчилан сэргийлэх болон цаг үеийн мэдээлэл, 5 шторкийг бэлтгэн байршуулсан.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд Сэлэнгэ аймгийн 15-34 насны бизнес эрхлэх сонирхолтой хувиараа хөдөлмөр эрхлэгч, албан бус салбарт ажилладаг болон ажилгүй залуучуудад зориулсан сургалт 2023 оны 11 сарын 10-ны өдөр цахимаар зохион байгуулагдаж хувиараа хөдөлмөр эрхлэгчид хамрагдлаа.

“Хөгжлийн бэрхшээлд хаалгаа нээе” өдөрлөгийг 2023 оны 11 сарын 15-ны өдөр зохион байгуулж, тус өдөрлөгөөр үзэсгэлэн худалдаа, ЭМТ-өөс витаминжуулалт, номын үзэсгэлэн худалдаа зэргийг зохион байгуулсан.

“Хүүхдэд ээлтэй хүчирхийлэлгүй сум” аяныг өрнүүлэн төр төсвийн байгууллагууд гадна дотно орчинд засвар үйлчилгээг тогтмол хийж, гамшгийн үед ажиллуулах дуут дохиолол, гадна камер байрлуулах дэлгэц зэргийг бэлтгэн байрлуулсан байна.

Шимэгчтэх өвчнөөс сэргийлэх ажлын хүрээнд угаалгад 54729 толгой, туулгад 60130 толгой, боловсруулалтад 48862 толгой малыг хамруулан ажиллаад байна.

Сайхан сум

Суманд 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Терроризмын нөхцөл байдал үүссэн үед ажиллах танхимын иж бүрэн сургуулилт зохион байгуулагдлаа. Уг сургуулилт нь Монгол Улсын хэмжээнд анх удаа суманд зохион байгуулагдаж байгаагаараа онцлог ач холбогдолтой. Танхимын сургуулилтаар 5 удаагийн цагийн байдал өгөгдөж, сумын Онцгой комисс, Шуурхай штабын бие бүрэлдэхүүн амжилтай зохион байгуулж ажиллалаа.

Ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын сурагчдын дунд “Хамтдаа шалгая” аяныг зохион байгуулж, тус аяны хүрээнд сургалтын байгууллагын орчны үнэлгээ болон хүүхэд гэр бүлийн орчны аюулгүй байдлын үнэлгээг зохион байгуулан ажиллалаа.

2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Хүүхдийн нэгдсэн чуулга уулзалтыг “Бидний дуу хоолой сэдэв”-ээр сумын ерөнхий боловсролын 3-н сургуулийн 8-10-р ангийн сурагчдын төлөөллийн оролцоотой зохион байгууллаа.

Тус чуулганаар:

1. Сумын удирдлагуудад хүргэх үг
2. Төрийн байгууллагад хүргэх үг
3. Эцэг, эх асран хамгаалагч нарт хүргэх үг
4. Олон нийтэд хүргэх үг гэсэн 4 дэд сэдвийн хүрээнд дэд хороод чуулан өөрсдийн саналаа хүргэж, сумын хүүхдийн зөвлөлийг зохион байгууллаа.

НҮБ-ын Хүүхдийн сан нь ЭМЯ-тай хамтарч “Амны хөндийн эрүүл ахуй, стрептококкийн халдвараар үүсгэгдсэн гүйлсэн булчирхайн үрэвсэлт өвчнийг эрт үед нь оношилж, эмчлэх” хөтөлбөрийг тус сумын хэмжээнд ЕБ-ийн 1,2-р сургуулийн 1-5 ангийн сурагчдын дунд гүйлсэн булчирхайн үрэвсэл буюу “Стрептококкын халдвараас сэргийлэх эрт илрүүлэг үзлэг шинжилгээ” 10 сарын 30,31-ны өдрүүдэд зохион байгуулж нийт 804 хүүхдэд шинжилгээ хийхээс 799 хүүхэд буюу 98,7 хувьтай хамруулсан байна.

Сант сум

Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн мэдээгээр сумын хэмжээнд 2 багийн 431 өрхөд нийт 104540 толгой мал түүний дотор адуу 6690, үхэр 17420, хонь 48630, ямаа 31800 толгой өвөлжүүлж хаваржуулна. Бэлчээрийн хүрэлцээ хангамж 86 хувьтай, өвөл хаврын бэлчээрийн дундаж ургац 6цн байна. Малчдын түвшинд 8630 тн байгалийн хадлан, 2002 тн ногоон тэжээлт, 2125 тн үйлдвэрийн тэжээл, 16 тн дарш, 260 тн хужир шүү бэлтгэн авч тэжээл бэлтгэл 99 хувьтай хангагдлаа. Өвс тэжээлийн аюулгүй нөөцөд өвс 60 тн бэлтгэн авахаас 37 тн, үйлдвэрийн тэжээл 40 тн бэлтгэн авахаас 40 тн бэлтгэн авсан байна. Малын тарга хүч 90 хувь нь дунд,

дундаас дээш тарга хүчтэй, мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажил 91,6 хувьтай хангагдсан.

Бог малын хээлтүүлэгчийг нийлүүлгийн бус үед сүргээс тусгаарлан суурилах ажлын хүрээнд хуц, ухна маллах хүсэлт өгсөн иргэдээс хоёр иргэнийг /Д.Дашлхам, Б.Сонинболд/ сонгон шалгаруулж, гэрээ хийн хуц ухна ялган суурилах ажлыг хийлээ. Ажлын явц 70 хувьтай байна.

“Копиа Монголи” төслийн хүрээнд 11 дүгээр сарын 08-ны өдөр ХААИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш Н.Нямаа “Бичил төсөл хийх” сургалтыг төсөлд хамрагдсан өрхүүдэд зохион байгууллаа. Төслийн зүгээс 20 өрхөд дэмжлэг үзүүлснээр эдийн засгийн байдалд хэрхэн өөрчлөлт орж байгааг судлах зорилгоор харьцуулсан судалгаа авч судалгаанд төсөлд хамрагдсан 20 өрх болон төслийн бус 5 өрх хамрагдлаа.

“Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслол”-ын үйл ажиллагааг 11 дүгээр сарын 24-ны өдрийн 17.00 цагт газарт зохион байгуулж, 3 албан хаагч шинээр тангараг өргөж, ёслолын үйл ажиллагаанд нийт 18 албан хаагч хамрагдаж хүндэтгэл үзүүллээ.

Сумын эрсдэлийн программд бүртгэлтэй эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 6 өрхийн 10 хүүхэд бүртгэлтэй байснаас нөхцөл байдлын үнэлгээ хийсэн 6 өрхийн 11 хүүхэд нэмж бүртгэлээ. Мөн Хамтарсан багийн гишүүд болон эцэг эхчүүдэд Хүүхэд хамгааллын талаар 2 удаагийн сургалт явуулж 25 хүн хамрагдлаа.

“Хамтдаа хамгаалъя, шалгая” аянд 4 төр, төсвийн байгууллагын “Эцэг эхийн зөвлөл”-ийг нэгтгэж байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийлгэж, илэрсэн зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгууллаа.

Сэлэнгэ аймгийн Орхон бүсийн ахмадуудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг урлаг спортын наадам “Долоон гайхамшиг” нэртэйгээр 2023 оны 11 дүгээр сарын 4,5-ны өдрүүдэд Сант суманд зохион байгуулагдаж 7 сумдын ахмадуудын төлөөлөл болсон 160 гаруй ахмадууд оролцов.

Сүхбаатар сум

Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж байгаа архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгжүүдэд хяналт тавьж, хориглосон цаг хугацаанд архи согтууруулах ундаа худалдан борлуулсан 3 зөрчлийг илрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр давхардсан тоогоор 456 аж ахуйн нэгж, 1920 иргэнд яриа таниулга хийж ажилласан.

“Алсын хараа - 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, шинэ сэргэлтийн бодлогын Хөдөөгийн сэргэлт зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 2023 оны 11 дүгээр сарын 17,18-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Нээлттэй Сэлэнгэ түмэн” арга хэмжээнд тус сум оролцож, орон нутгаа сурталчлах ажлыг зохион байгуулж, сумын танилцуулга, тараах материалыг 500 гаруй иргэнд тарааж ажилласан.

“Орос хэл соёлын баяр”-ын арга хэмжээний үеэр “Мэргэжил сонголт” тусгай хөтөлбөрийг төгсөх ангийн сурагчдад танилцуулж, Оросын Холбооны Улсад суралцах боломжийн талаар танилцуулсан. Үүнд:

- Оросын Холбооны Улсад суралцах боломж ,Засгийн газрын тэтгэлэг, сургуулиудын мэдээлэл,
- Буриад Улсын их сургуулийн танилцуулга,
- Буриад Улсын их сургуулийн оюутнуудын урлагийн тоглолт,

- “Салют – 7” уран сайхны кино үзүүлэх зэрэг арга хэмжээнд сумын ерөнхий боловсролын сургуулийн 10-12 ангийн нийт 500 гаруй сурагчдыг оролцуулсан.

ОХУ-ын Эрхүүгийн үндэсний судалгаа, техникийн их сургуулийн төлөөлөгчид Сүхбаатар суманд ажиллаж буй Орос хэлний багш нарт зориулсан сургалтад 7 сургуулийн 12 багш хамрагдсан.

“УР АВЪЯАС-2023” ур чадварын уралдааныг Улсын тэргүүний 4-р цэцэрлэгт зохион байгуулж, 9-н цэцэрлэгийн багш нар хамрагдан харилцан туршлага солилцлоо.

“Бүх нийтийн соёлын боловсрол хөтөлбөр”-ийн хүрээнд чадавхжуулах сургалтад ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 30 номын санч нийгмийн ажилтан нар хамрагдсан.

Ерөнхий боловсролын 4 сургууль, 3 цэцэрлэгүүдэд “Сургууль цэцэрлэгийн орчны аюулгүй байдал”, “Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх” нь сэдэвт сургалтыг аймгийн Улаан Загалмай Хороо, Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулсан.

Дэлхийн Зөн Монгол Олон улсын байгууллага, Монгол өрх сэтгэлзүйн хүрээлэн, Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар хамтран тус сумын “Гэрээр айлчлагч аргачлал”-д хамрагддаг иргэдэд “Хувь хүний хөгжил-Амьдралын чанар”, “Хариуцлагатай Хамтарсан баг” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Дээрх сургалтад сумын Хамтарсан багийн 42 гишүүн, 1-8 дугаар багт “Гэрээр айлчлагч” хөтөлбөрт хамрагддаг 46 өрхийн иргэд хамрагдаж, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 9 өрхийн 4 иргэн, 8 хүүхдэд сэтгэл зүйчийн зөвлөгөө өгч ажилласан.

УИХ-ын гишүүн Д.Өнөрболорын дэмжлэгээр Улаанбаатар хотын Нэгдүгээр төв эмнэлгийн эмч нарын баг Сүхбаатар сумын 8 багийн иргэд рүү чиглэсэн нарийн мэргэжлийн үзлэг оношилгоог эхлүүлсэн.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын ажлыг 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны хооронд хийж гүйцэтгэж, Сүхбаатар сумын хэмжээнд 253 өрхийн 7023 толгой үхэр, 45 өрхийн 1277 толгой гахай, нийт 298 өрхийн 8300 толгой мал амьтныг бүрэн хамрууллаа.

Сумын ургац хураалтын задаргааг гаргаж аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн. Сумын хэмжээнд 2023 оны 11-р сарын байдлаар ургац хураалтын ажил 100 хувьтай явагдаж дууссан.

Хүнс хөдөө аж ахуйн газраас Нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний явуулдаг байгууллагуудад зохион байгуулсан “Хууль тогтоомж сурталчлах, арга зүйн мэдлэгийг дээшлүүлэх” сургалтад 35 аж ахуй нэгж, иргэнийг хамруулсан.

Түшиг сум

Эцэг эх, асран хамгаалагч, иргэд олон нийт, аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоотойгоор хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, ахуйн осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, орчныг үнэлж шаардлагатай арга хэмжээг авах ажлыг зохион байгуулж “ХАМТДАА ШАЛГАЯ, ХАМТДАА ХАМГААЛЪЯ” аяныг өрнүүллээ.

Нээлттэй Сэлэнгэ түмэн арга хэмжээнд уул уурхайн 3 аж ахуйн нэгж аялал жуулчлалын 2 аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагааны талаарх танилцуулга, мэдээллийг бэлтгүүлэн оролцоог ханган ажиллалаа.

Хүүхэд хүчирхийлэлд өртөх болон эрсдэлтэй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж “Гараас гарт” журмыг хэрэгжүүлэн өдөр бүр гарын үсгийн баталгаагаар эцэг эхэд хүүхдийг хүлээлгэн өгөх ба хүлээн авч байна. Мөн цэцэрлэгийн орчимд явган хүний гарцын тэмдэг тэмдэглэгээг шинээр хийлээ.

“ХАМТДАА ШАЛГАЯ, ХАМГААЛЪЯ” аян арга хэмжээний хүрээнд сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс аялуулж буй “1 дүгээрт хүүхэд”, “Бид хамгаалж чадна” самбарыг хүлээн авч аяныг өрнүүллээ.

Сумын аюулгүй нөөцөд бэлтгэх өвс, тэжээлийн хэмжээг малын тоог харгалзан үзэж 7307 тн өвс, 1352 тн үйлдвэрийн тэжээл, 100 тн давс, хужир бэлтгэж өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангасан байна.

Залуу багшийн мэргэжлийн өсөлтийг дэмжих цахим хичээл бэлтгэн заах залуу багш нарын ур чадварын уралдаан ажлын 12 хоног амжилттай зохион байгуулагдлаа.

Ерөнхий боловсролын сургуулийн математикийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, чанарыг сайжруулах "EDUTEN" цахим системийг нэвтрүүлэх сургалтыг Сэлэнгэ аймгийн сургалтын менежерүүд, бага боловсролын багш нарт 2023 оны 11 дүгээр сарын 8,9-ний өдрүүдэд цахимаар зохион байгууллаа.

Товлолт дархлаажуулалтад 19 хүн дархлаажуулж дархлаажуулалтын дараах урвал хүндрэл гараагүй. Сургуулийн насны хүүхдүүдийн дунд Стрептококкийн халдварыг эрт илрүүлэг, үзлэг оношилгоо шинжилгээг 10 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулж 1-5 дугаар ангийн 170 сурагчдыг 100 хувь хамруулж хариу эерэг гарсан сурагчдын асран хамгаалагчтай нь уулзаж дээд шатны байгууллагад оношилгоо шинжилгээнд хийлгэх талаар заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Эмийн аюулгүй байдлын 7 хоногийн аяны хүрээнд эмийн санч, арга зүйч нар төр төсвийн байгууллагын албан хаагчдад эмийн гаж нөлөөг хүн бүр мэдээлэх боломжтой сэдвээр 80 гарын албан хаагчдад сургалт гарын авлага тараасан.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс зохион явуулсан сэтгэц, мэдрэл, донтолтын үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээ сэдэвт 3 хоногийн сургалтад их эмч нар хамрагдсан.

Эрүүл мэндийн газраас зохион явуулсан “Халдварын сэргийлэлт, хянах тогтолцоог сайжруулах” сургалтад 2 үйлчлэгч хамрагдаж мэдлэгээ дээшлүүлэн ажиллалаа.

Хушаат сум

11 сарын 20-ны байдлаар "Хушаат мэдээ" сониныг 8 дугаар 700 ш хэвлэн багийн дарга нарт, Бичиг хэргийн ажилтан Захиргааны хэргийн акт 2 төрлөөр 180 ш, нэрийн хуудас 2 төрлийн 150 ш, ажлын үнэмлэх 15 ш, өрөөний хаяг 12 ш, сумын ЗД-ын жуух бичиг 10 ш, өргөмжлөл 28 ш, дарцаг 50 ш, дугтуй 50 ш, сумын танилцуулга 100 ш, брошюр 4 төрөл 360 ш, санамж 4 төрөл 400 ш, цээж зураг 12 ш, самбарын эх 2 ш, КЦТ танилцуулгын эх 3 ш, сумын угтах самбар эх 3 ш, сэрэмжлүүлгийн самбарын эх 4 ш тус тус бэлтгэн, хэвлэн тараах ажлыг хийсэн байна

"Урианхай сурын цуваа харваа"-ны тэмцээнийг Сэлэнгэ аймгийн Харваачдын холбоотой хамтран зохион байгуулахад 28 харваач оролцож цэц мэргэн, хурд хүч, авхаалж самбайгаа сорин харвалаа.

ЕБС-д үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэл дарамтыг арилгах, хүүхдэд эерэг хандлага, эрүүл, зөв зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор “Сэтгэл ханамжийн судалгаа”-г 1-12-р ангийн сурагчдаас авч, үе тэнгийн дээрэлхэлтийн шалтгааныг

тогтоож, анги бүр үе тэнгийн дүрэм журам боловсруулж сургуулийн хэмжээнд дээрэлхэлтийн эсрэг сургуулийн соёлыг гарган ажиллаж байна, ингэснээр сурагчдын сэтгэл ханамжийн байдал 5 хувиар өссөн.

Хүүхдийг ахуйн орчны осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх судалгааг АУБ нар 14 хоногт 1 удаа төлөвлөгөөний дагуу явуулж 343 сурагч хамрагдлаа.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Цагдаагийн хэсэгтэй хамтран хөвгүүдийн яриа хийж утаат тамхи, хийн газ, цавууны талаарх хор хөнөөлийн талаар 6-12 ангийн 75 сурагчдын дунд тайлбарлан, мэдээлэл хийлээ.

“Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ”-г хамтран дараах чиглэлээр зохион байгуулагдлаа.

- Хамтарсан баг, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын багийн гишүүдийг ажлын байран дээр зөвлөн туслан, хамтран ажиллан зөвлөгөө мэдээллээр ханган ажиллаа.
- ЕБС-н суралцагч, эцэг эх, харгалзан дэмжигч, асран хамгаалагчдад сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгч нийт 9 сурагч зөвлөгөө авлаа.
- Иргэд, олон нийтэд Аз жаргалыг бүтээх тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийг сурталчилсан сургалт нөлөөллийн ажлыг зохион байгууллаа.
- Аймгийн Засаг даргын 03 тоот албан даалгаврын хэрэгжилтийн үйл явц, зөвлөгөө мэдээллээр ханган ажиллаа.
- "Хамтдаа шалгая, хамгаалъя" арга хэмжээний явц, үйл ажиллагааны хэрэгжилттэй танилцан мэдээллээр ханган ажиллаа.

“Үлгэрийн орноор аялсан нь” үйл ажиллагаанд 4 бүлгийн нийт 67 хүүхэд багачууд 5 үлгэрээр жүжигчилсэн тоглолт хийж оролцлоо.

Хүдэр сум

“Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх намрын дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах” ажлын хүрээнд сумын хэмжээнд үхэр, гахайг яаралтай дархлаажуулах ажил хийгдсэн.

Өвөлжилтийн бэлтгэл ажил хангах ажлын хүрээнд бизнесийн зориулалтаар хадлан бэлтгэсэн иргэдээс сумын фонд өвсийг бүрдүүлэн ажиллаж байна. Одоогийн байдлаар 13 иргэний 700 тн өвс нөөцөд бүртгэгдсэн байна.

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах иргэдийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилгоор Ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн 20 сурагчдад “Эрхзүйн орчин дахь хүүхэд хамгаалал” сэдвээр, эцэг, эх асран хамгаалагчдад “Гэмт хэрэг зөрчлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх арга зүй” сэдвээр 20 иргэнд сургалт мэдээ мэдээллийг нийт 40 хүнд хүргэж тараах материал тараан ажилласан.

Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд “Үгийн эрэлд”, “Алдаагүй зөв бичигтэн” уралдааныг зохион байгуулсан. Тус уралдааныг зохион байгуулснаар бага ангийн сурагчдын зөв бичих чадварт 15-23 хувийн ахицтай суралцсан байна.

“Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн хүрээнд сумын 145 төрийн албан хаагчдыг үндэсний бичгийн түвшин тогтоох шалгалтыг зохион байгуулж шалгалтаар анхан шатанд 98, дунд шатанд 47 албан хаагч хамрагдаж долоо хоног бүр 2 удаагийн сургалтыг насан туршийн боловсролын төв зохион байгуулан ажиллаж байна.

Цагааннуур сум

Австралийн нарийн ноост үүлдрийн хуцын үрээр дурангийн аргаар хээлтүүлсэн 100 хээлтэгчийг татан авч, 15 хурган хуц, 3 нас гүйцсэн хуц хээлтүүлэгд ашиглуулах гэрээнүүдийг хийж, 3 үндсэн хуцыг хүлээлгэн өгөв.

11 дүгээр сарын 23-ний байдлаар 15000 тн өвс, 212 тн хужир, 200 тн ногоон тэжээл бэлтгэсэн байна. Сумын өвөлжилтийн бэлтгэл ажлын гүйцэтгэл 99,8 хувьтай байна.

Намрын ургац хураалтын эцсийн мэдээг нэгтгэн тайланг гарган ажилласан. Үүнд: Улаанбуудай 20989 га-д тариалалт хийж 20455 га талбайг хураан авч, арвай 219 тн, овьёос 320,95 тн, тэжээлийн ургамал 9516 тн, тосны ургамал 6369 тн, төмс 60,8тн , хүнсний ногоо 228 тн ургац тус тус хураан авсан байна.

2023 оны 11 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд Улаанбаатар хотод болсон “НЭЭЛТТЭЙ СЭЛЭНГЭ” арга хэмжээнд сумын 1 хоршоо, 2 зөгийн аж ахуй эрхлэгч иргэн, 2 хүнсний ногооны тариалан эрхлэгчдийг тус арга хэмжээнд хамруулан ажилласан ба уг арга хэмжээнд 3 иргэн, 1 ААН-ийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа.

Ойн мэргэжлийн байгууллага “Бүтээлийн нуур” ХХК-ний 2023 онд мод бэлтгэх гүйцэтгэлийн дагуу үйлдвэрлэлийн огтлолтын шинэс хэрэглээ 200м3 модонд 14.2 га талбай тусгаарлалтыг ойн ангийн хамт хийж гүйцэтгэсэн.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх намрын вакцинжуулалтын арга хэмжээнд нийт 29800 толгой үхэр, 1300 толгой гахай тус тус хамруулахаар зохион байгуулан ажиллаж байна.

Яаралтай дархлаажуулалтын ажлыг 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 07-ны өдөр хүртэл хугацаанд тарьсан. Тарилгын дараа болон тарилгын явцад вакцинжуулалт хийсэн мал, амьтанд ямар нэг хүндрэл, вакцинаас нөлөөлөх сөрөг шинж тэмдэг илрээгүй болно.

Шаамар сум

“Нээлттэй Сэлэнгэ” арга хэмжээнд ЗДТГ болон сумын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, хоршоологчид зэрэг 9 иргэний бүрэлдэхүүнтэйгээр оролцсон. Арга хэмжээнд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэд, бүл, хоршоологчдын үйлдвэрлэсэн брэнд 11 бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдаанд оролцуулж, төрийн алба, орон нутгаа сурталчлах ажилд Соёлын төв, ЗДТГ-ын 6 албан хаагчдыг оролцууллаа.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын арга хэмжээг 100 хувийн гүйцэтгэлтэй хийж гүйцэтгэлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн хүрээнд “Ой цэвэрлэх” ажилд амьжиргааны түвшнээс доор орлоготой өрхийн 10 иргэнийг 7 хоногийн хугацаатай ажиллуулж 40 га талбайг цэвэрлүүлсэн.

Нийт иргэнд үйлчилгээний нэгдсэн төвөөр гарах лавлагааны мэдээллийг өгч ажилласан. 10 иргэний утсанд апп суулган бүртгүүлж 10 лавлагаа үйлчилгээг иргэнд гарган өгч заавар зөвлөгөө өгсөн. Шаамар сумын операторын үйлчилгээгээр нийт 33 иргэнд лавлагаа мэдээлэл гаргасан байна.